



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

57

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 31

Мандалговь

Хөрөнгөнд үнэлгээ тогтоож, худалдах, акталж
сэлбэг хэрэгсэлд бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 19,400,000 /арван есөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 53-39 ДУА улсын дугаартай УАЗ-31519 маркийн автомашины худалдах доод үнийг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр, 1,900,000 /нэг сая есөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй бага оврын тракторыг акталж, данснаас хасах, 37,799,960 /гучин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун жар/ төгрөгийн балансын үнэтэй, 28,349,969 /хорин найман сая гурван зуун дөчин есөн мянга есөн зуун жаран ес/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй, 52-08 ДУА улсын дугаартай Патриот маркийн автомашиныг акталж, данснаас хасах нэгдүгээр хавсралтаар, “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 4,010,000 /Дөрвөн сая арван мянга/ төгрөгийг сэлбэг хэрэгслийг дансанд бүртгэж, балансаас балансад шилжүүлэхийг хоёрдугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Говь-Угтаал сумын тамгын дарга (Г.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

Дөрөв: Говь-Угтаал сумын тамгын дарга (Г.Эрдэнэцэцэг), “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Д.Ганбаатар) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх

Тав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны Дугаар сарын
23-ний өдрийн А. тогтоолын нэгдүгээр хавсралт

**Говь-Угтаал сумын Засаг даргын тамгын газрын актлах, худалдах,
сэлбэг хэрэгсэлд бүртгэх тээврийн хэрэгслийн мэдээлэл**

Д/д	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	дугаар						
1	УАЗ 31519	УАЗ	ДУА	53-39	2010	2010	55066	19,400,000	19,400,000	-
2	Бага оврын трактор				2009	2009		1,900,000	1,900,000	-
3	Патриот	УАЗ	ДУА	52-08	2016	2016	57094	37,799,960	9,449,990.10	28,349,969.90
Нийт дүн										
									30,749,990.10	28,349,969.90
									/гучин сая	/хорин найман
									долоон зуун	сая гурван зуун
									дөчин есөн	дөчин есөн мянга
									мянга есөн зуун	есөн зуун жаран
									ерэн төгрөг	ес төгрөг ерөн
									арван мөнгө/	мөнгө/

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 13 дугаар сарын
13-ний өдрийн 11 тогтоолын хоёрдугаар хавсралт

**Патриот автомашины тээврийн хэрэгслээс авах,
сэлбэг хэрэгслийн жагсаалт**

№	Сэлбэгийн нэр	х/н	тоо/ш	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цахилгааны цээж утас	ком	1	50,000.00	50,000.00
2	Радиатор	ш	1	100,000.00	100,000.00
3	Жинам	ш	1	70,000.00	70,000.00
4	Күлекторын оруулах Хоолой	ш	1	50,000.00	50,000.00
5	Катушик	ш	2	30,000.00	60,000.00
6	Клапан	ш	1	60,000.00	60,000.00
7	Клапангийн таг	ш	1	30,000.00	30,000.00
8	Клапангийн тагны жийрэг	ш	1	10,000.00	10,000.00
9	Сэнс	ш	1	50,000.00	50,000.00
10	Сэнсний хүрээ	ш	1	25,000.00	25,000.00
11	Духны гинж	ш	1	150,000.00	150,000.00
12	Цахилгаан помп	ш	1	40,000.00	40,000.00
13	Кондишны жинам	ш	1	50,000.00	50,000.00
14	Агаар шүүгч	ш	1	5,000.00	5,000.00
15	Агаарын хоолой	ш	2	10,000.00	20,000.00
16	Статер	ш	1	120,000.00	120,000.00
17	Хойд нум	ком	1	80,000.00	80,000.00
18	Урд пүрш	ш	2	40,000.00	80,000.00
19	Мотрын ламп	ш	1	20,000.00	20,000.00
20	Урд хойд цафны шайриг	ш	8	15,000.00	120,000.00
21	Стуч	ш	8	40,000.00	320,000.00
22	Мотор	ш	1	2,500,000.00	2,500,000.00
Дүн					4,010,000.00 /дөрвөн сая арван мянган төгрөг/